# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 270. | Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1146 |
| 271. | Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1152 |
| 272. | Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 1154 |
| 273. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 1154 |


## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 274. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 92 | 1155 |
| 275. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 93 | 1155 |


## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 276. | 2012 онд энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг оролцуулах болон хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах тухай | Дугаар 69 | 1156 |
| 277. | Жагсаалт батлах тухай | Дугаар 71 | 1161 |
| 278. | Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 78 | 1163 |
| 279. | Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 79 | 1173 |
| 280. | Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай | Дугаар 80 | 1174 |

| | | | |
|---|---|---|---|
| 281. | Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 81 | 1174 |
| 282. | Орон сууцны санхүүжилтийн зээлийн гэрээ байгуулах тухай | Дугаар 83 | 1175 |
| 283. | Журам батлах тухай | Дугаар 85 | 1176 |
| 284. | Ажлын хэсэг байгуулах тухай | Дугаар 87 | 1177 |
| 285. | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 88 | 1180 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар сарын 09-ний өдөр — Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Боловсролын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.1.13-3.1.15 дахь заалт:**

“3.1.13.“олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль” гэж олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий боловсролын хөтөлбөрөөр хичээллэдэг сургуулийг;

3.1.14.“ерөнхий боловсролын лаборатори сургууль” гэж бага, дунд боловсролын судалгаа, арга зүйн туршилтыг зохион байгуулах ерөнхий боловсролын сургуулийг;

3.1.15.“боловсролын туслах ажилтан” гэж бүх шатны боловсролын сургалтын байгууллагын нягтлан бодогч, нярав, тогооч, манаач, үйлчлэгч, мужаан, цахилгаанчин, слесарь, галч болон үйлчилгээний бусад ажилтныг.”

**2/9 дүгээр зүйлийн 9.3, 9.4 дэх хэсэг:**

“9.3.Ерөнхий боловсролын сургууль, албан бус боловсролын төв нь сургалтын баримт бичиг болох сурагчийн хувийн хэрэг, ангийн журналыг хөтөлнө.

9.4.Сургалтын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

**3/16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг:**

“16.5.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь дараах чиглэлээр судалгаа, шинжилгээ, сургалтын ажлыг тасралтгүй эрхлэх байнгын бүтэцтэй байна:

16.5.1.боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөр, сурагчдын мэдлэг, чадвар, дадлын үнэлгээ, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэжил дээшлүүлэх;

16.5.2.сурах бичгийн агуулга, арга зүй, боловсролын удирдлага, хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хөгжил, мэдээлэл, холбооны технологид суурилсан сургалт.”

**4/17$^{1}$ дүгээр зүйл:**

**“17$^{1}$ дүгээр зүйл.Боловсролын үнэлгээний байгууллага**

“17$^{1}$.1.Боловсролын үнэлгээний байгууллага нь /цаашид “Боловсролын үнэлгээний төв” гэх/ сурлагын амжилт, бүх шатны боловсролын сургалтын чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах ерөнхий боловсролын түвшин, суралцагчдын мэдлэг, чадварыг тогтоох зорилго бүхий элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн.

17$^{1}$.2.Боловсролын үнэлгээний төвийн бүтэц, орон тоо, дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**5/20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг:**

“20.2.Төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургууль, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалттай сургууль, цэцэрлэгийг байгуулах тусгай зөвшөөрлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

**6/28 дугаар зүйлийн 28.1.22- 28.1.25 дахь заалт:**

“28.1.22.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам батлах;

28.1.23.төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам батлах;

28.1.24.сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам батлах;

28.1.25.төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийн тусгай арга хэмжээ, хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтыг хэрэгжүүлэх журам боловсруулж батлах;"

**7/28 дугаар зүйлийн 28.3, 28.4 дэх хэсэг:**

"28.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол, хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандарт, норм, нормативыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, эрх бүхий байгууллага батална.

28.4.Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэжлийн зэрэг, нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална."

**8/28$^{1}$ дүгээр зүйлийн 28$^{1}$.1.9 дэх заалт:**

"28$^{1}$.1.9.аймаг, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дүрэмт хувцасны нэгдсэн загварыг батлах."

**9/30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалт:**

"30.1.15.аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх;"

**10/35 дугаар зүйлийн 35.4.8 дахь заалт:**

"35.4.8.сургалтын төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох."

**11/35 дугаар зүйлийн 35.7 дахь хэсэг:**

"35.7.Энэ хуулийн 35.4.8 дахь заалт нь зөвхөн төрийн өмчийн бус сургууль, цэцэрлэгийн зөвлөлд хамаарна."

**12/39 дүгээр зүйлийн 39.12, 39.13 дахь хэсэг:**

“39.12.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

39.13.Боловсролын үнэлгээний байгууллага нь улсын төсөв, судалгааны ажлын орлого их, дээд сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалтын хураамжийн орлогоос санхүүжнэ.”

**13/40 дүгээр зүйлийн 40.8 дахь хэсэг:**

“40.8.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийн зэрэг, ур чадварыг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутам дээшлүүлнэ.”

**14/42 дугаар зүйлийн 42.7, 42.8 дахь хэсэг:**

“42.7.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шинээр барих сургууль, цэцэрлэгийн урт хугацааны төлөвлөлтийг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, сургууль, цэцэрлэгийн эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг сургалтын орчинд тавигдах шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд авах шийдвэр гаргана.

42.8.Энэ хуулийн 42.7-д заасны дагуу шинээр барих сургууль, цэцэрлэгийн нөөцийн газрыг өөр зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах, худалдахыг хориглоно.”

**15/43 дугаар зүйлийн 43.4- 43.6 дахь хэсэг:**

“43.4.Боловсролын сургалтын байгууллагын нийт албан хаагчийг 5 жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулах арга хэмжээг аймаг, нийслэлийн Засаг дарга боловсролын болон эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

43.5.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, бусад албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгох бөгөөд уг урамшууллын хэмжээ, түүнийг олгох журмыг Төрийн албаны тухай хуулийн 31.3-т заасны дагуу Засгийн газар батална.

43.6.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 3.1.15-д заасан албан тушаалд 25 ба

түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 12 сарын, сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт 10 ба түүнээс жил ажилласан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 18 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгана.”

**2 дугаар зүйл.**Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “сөрөг нөлөө бүхий сургалт” гэсний дараа “, гадаад улсын санхүүжилт, зохион байгуулалттайгаар шашны чиглэлээр сургалт, шашны зан үйл, бусад үйл ажиллагаа” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “арга зүйн” гэсний дараа “, боловсролын үнэлгээний” гэж, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “байгууллагын” гэсний дараа “бүтэц, орон тоо,” гэж, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “Албан бус боловсролын” гэсний дараа “сургалт,” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “15.7.4,” гэсний дараа “15.7.8, 15.7.9,” гэж, 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсгийн “мэргэжлийн чиглэл” гэсний дараа “, олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын онцлог” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Боловсролын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг:**

“16.1.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлого, шийдвэр боловсруулахад судалгааны мэдээллээр хангах, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын асуудлаар байнгын судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх, орон нутгийн боловсролын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бүх шатны боловсролын байгууллагад сургалт, судалгаа, арга зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа явуулах, иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааг эрхэлнэ.”

**2/17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг:**

“17.1.Албан бус боловсролын сургалт, судалгаа, арга зүйн байгууллага нь албан бус боловсролын бодлого, шийдвэр боловсруулахад судалгааны мэдээллээр хангах, албан бус боловсрол, насан туршийн тасралтгүй боловсролын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үндэсний түвшинд зохион байгуулах, орон нутгийн албан бус боловсролын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, албан бус боловсрол олгож байгаа багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааг эрхэлнэ.”

**3/43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалт:**

“43.1.4.бүх шатны сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 24 сарын, үүнээс сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан бол 36 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг төрийн албан хаагчийн цалингийн сүлжээг баримтлан улсын төсвөөс өмчийн хэлбэрийг үл харгалзан ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох;”

**4/43 дугаар зүйлийн 43.1.7 дахь заалт:**

“43.1.7.сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн багш, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, туслах багш, сургуулийн номын санч, сургууль, цэцэрлэгийн эмчид 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгох;”

**4 дүгээр зүйл.**Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалтын “боловсролын нийгмийн ажилтан” гэснийг “сургуулийн нийгмийн ажилтан” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.12 дахь заалтын “улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага, албан бус боловсролын сургалт, судалгаа, арга зүйн байгууллага, төрийн өмчит олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийн” гэж, 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийн “төв” гэснийг “газар” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.22 дахь заалтын дугаарыг “28.1.26” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалтын дугаарыг “30.1.16” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.5 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

## БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Бага, дунд боловсролын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсэг:**

“12.8.Төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, орон тоо, дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

**2 дугаар зүйл.**Бага, дунд боловсролын тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг:**

“7.2.Бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд тус тус эзэмшүүлнэ.”

**2/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:**

“12.3.Ерөнхий боловсролын сургууль нь ердийн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, тусгай, олон улсын хөтөлбөрийн сургалттай гэсэн хэв шинжтэй байна.

**3/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:**

“14.1.Урлаг, спорт, зохион бүтээх зэрэг чиглэлээр суралцагчийн авьяас, чадварыг багаас нь хөгжүүлэх зорилгоор байгуулсан ерөнхий боловсролын сургуульд тусгай хөтөлбөрийн дагуу явуулж буй сургалтыг төрөлжсөн сургалт гэнэ.”

**4/14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:**

“14.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хөтөлбөрийн дагуу явуулж байгаа бүх нийтийн ерөнхий боловсролын стандартаас давсан агуулга бүхий сургалтыг гүнзгийрүүлсэн сургалт гэнэ.”

**5/14 дүгээр зүйлийн 14.5, 14.6 дахь хэсэг:**

“14.5.Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

14.6.Төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, олон улсын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

**6/14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсэг:**

“14.8.Төрөлжсөн болон олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**3 дугаар зүйл**.Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “төлөвлөгөөг” гэснийг “төлөвлөгөө, хөтөлбөрийг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “Бүрэн дунд” гэснийг “Суурь, бүрэн дунд,” гэж, 14 дүгээр зүйлийн гарчгийн “Мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай” гэснийг “Төрөлжсөн, олон улсын хөтөлбөрийн болон гүнзгийрүүлсэн сургалттай” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “Мэргэжлийн” гэснийг “Төрөлжсөн” гэж, мөн 14.9 дэх хэсгийн “Мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн” гэснийг “Гүнзгийрүүлсэн” гэж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “мэргэжлийн сургалтын дадлага, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн” гэснийг “төрөлжсөн” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Бага, дунд боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв,” гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.**Бага, дунд боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2, 14.7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

## СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 9.10 дахь хэсэг нэмсүгэй:

“9.10.Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтыг зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

## АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 15.7.8, 15.7.9 дэх заалт нэмсүгэй:

“15.7.8.олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийг байгуулах;

15.7.9.гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг, сургууль байгуулах.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 92 | Улаанбаатар хот

**Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Л.Бямбааг Улсын Дээд шүүхийн шүүгчийн, Д.Алимааг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Ц.ЭЛБЭГДОРЖ**

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 93 | Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4, 42 дугаар зүйлийн 42.3, 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

1.Түндэвийн Даваасүрэнг Архангай аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Гэндэндоржийн Болормааг Дорноговь аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Чадраабалын Энхтөрийг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн, Дашнямын Цогтсайханыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан, Чойжилын Оюунгэрэлийг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Нямжавын Туяаг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн, Төмөрбаатарын Болормааг Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн, Батбаярын Мөнхбаярыг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Санги-Очирын Олзодыг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд сэлгэн ажиллуулсугай.

3.Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Түндэвийн Даваасүрэнг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Гэндэндоржийн Болормааг Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Нямжавын Туяаг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Санги-Очирын Олзодыг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙЛӨГЧ Ц.ЭЛБЭГДОРЖ**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр — Дугаар 69 — Улаанбаатар хот

**2012 онд энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг оролцуулах болон хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах тухай**

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.2012 онд энхийг дэмжих ажиллагаанд Зэвсэгт хүчнээс цэргийн баг оролцуулах болон олон улсын хамтарсан сургалт дадлага зохион байгуулах арга хэмжээний жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2.Энхийг дэмжих ажиллагаа болон олон улсын хамтарсан сургалт, дадлагад цэргийн баг оролцуулахад шаардагдах зардлыг 2 дугаар хавсралт ёсоор баталж, 1,376,463,280 (нэг тэрбум гурван зуун далан зургаан сая дөрвөн зуун жаран гурван мянга хоёр зуун наян) төгрөгийн үнэ бүхий техник, материал хэрэгслийг Зэвсэгт хүчний нөөцөөс, 244,199,800 (хоёр зуун дөчин дөрвөн сая нэг зуун ерэн есөн мянга найман зуун) төгрөгийн үнэ бүхий техник, материал хэрэгслийг Зэвсэгт хүчний урсгал хангалтаас гарган, гүйцэтгэлийг эргэн тооцохыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга Ц.Бямбажавт, энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн албан хаагчдын гадаад томилолтын зардалд шаардагдах 10,743,480,000 (арван тэрбум долоон зуун дөчин гурван сая дөрвөн зуун наян мянган) төгрөгийг энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрөөс, бусад шаардлагатай материал, хэрэгслийг худалдан авахад шаардлагатай 4,414,659,910 (дөрвөн тэрбум дөрвөн зуун арван дөрвөн сая зургаан зуун тавин есөн мянга есөн зуун арван) төгрөгийг төсвийн багцаасаа гаргаж, зарцуулахыг Батлан хамгаалахын сайд Ж.Энхбаярт зөвшөөрсүгэй.

3. Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах цэргийн багуудын бэлтгэлийг сайтар хангаж, цэргийн багуудын ээлж солилцох ажиллагаа болон олон улсын хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Батлан хамгаалахын сайд Ж.Энхбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга Ц.Бямбажав нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД** **Ж.ЭНХБАЯР**

Засгийн газрын 2012 оны 69 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

## 2012 ОНД ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭС ЦЭРГИЙН БАГ ОРОЛЦУУЛАХ БОЛОН ОЛОН УЛСЫН ХАМТАРСАН СУРГАЛТ, ДАДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

| № | Арга хэмжээ | Хүний тоо | Хэзээ болох |
|---|---|---|---|
| | 1. Энхийг дэмжих ажиллагаа | | |
| 1 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан VI ээлжийн цэргийн баг оролцуулах | 126 | III сар |
| 2 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан VII ээлжийн цэргийн баг оролцуулах | 126 | VIII сар |
| 3 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд XIV ээлжийн артиллерийн сургалтын хөдөлгөөнт баг оролцуулах | 24 | III сар |
| 4 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд XV ээлжийн артиллерийн сургалтын хөдөлгөөнт баг оролцуулах | 24 | VIII сар |
| 5 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан VI ээлжийн цэргийн баг оролцуулах | 154 | IV сар |
| 6 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан VII ээлжийн цэргийн баг оролцуулах | 154 | X сар |
| 7 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нисдэг тэрэгний засвар үйлчилгээний IV ээлжийн цэргийн баг оролцуулах | 6 | III сар |
| 8 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нисдэг тэрэгний засвар үйлчилгээний V ээлжийн цэргийн баг оролцуулах | 6 | VIII сар |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд Бельги Улсын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэх нисэх онгоцны буудлын хамгаалалтын салааны III ээлжийн цэргийн баг | 57 | IV сар |
| 10 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд Бельги Улсын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэх нисэх онгоцны буудлын хамгаалалтын салааны IV ээлжийн цэргийн баг | 57 | X сар |
| 11 | Судан Улсын Дарфур муж дахь НҮБ, Африкийн холбооны хамтарсан энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн хээрийн II шатны эмнэлгийн III ээлжийн цэргийн баг | 68 | VI сар |
| 12 | Судан Улсын Дарфур муж дахь НҮБ, Африкийн холбооны хамтарсан энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн хээрийн II шатны эмнэлгийн IV ээлжийн цэргийн баг | 68 | XII сар |
| 13 | Өмнөд Судан Улс дахь НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцох Мотобуудлагын батальоны I ээлжийн цэргийн баг | 850 | V сар |
| 14 | Өмнөд Судан Улс дахь НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцох Мотобуудлагын батальоны II ээлжийн цэргийн баг | 850 | IX сар |
| 2. Монгол Улсад зохион байгуулах олон улсын хамтарсан сургалт, дадлага | | | |
| 15 | Катар Улстай хамтарсан "Шийдэмгий шийдвэр" сургалт, дадлага | 300 | VI сар |
| 16 | БНХАУ-тай хамтарсан "Энхийн элч" сургалт, дадлага | 100 | VII сар |
| 17 | Турк Улстай хамтарсан "Нүүдэлчин дайчин" тусгай хүчний сургалт, дадлага | 160 | VIII сар |
| 18 | “Khaan quest” энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургалт, дадлага | 800 | VIII сар |
| 19 | “Олон улсын хүчний тогтсон ажиллагааны журам” олон улсын төлөвлөлтийн багийн команд штабын сургууль | 100 | VI сар |
| 20 | АНУ-ын “Дэлхийн энхийн ажиллагааны сан”-тай хамтарсан сургалтууд | 150 | IV-VIII сар |
| 3. Бусад улсад зохион байгуулагдах олон улсын сургалт, дадлага | | | |
| 21 | Бангладеш Улсад зохион байгуулагдах "Shanti doot-3" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургалт, дадлага | 45 | III сар |
| 22 | БНЭУ-д зохион байгуулагдах "Нүүдэлчин заан" сургалт, дадлага | 40 | X сар |
| 23 | ОХУ-д зохион байгуулагдах "Сэлэнгэ-2" хээрийн сургалт, дадлага | 250 | IX сар |
| 24 | Турк Улсад зохион байгуулагдах "Анадолу" тусгай хүчний олон улсын сургалт, дадлага | 30 | IX сар |

Засгийн газрын 2012 оны 69 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

## 2012 ОНД ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА БОЛОН ОЛОН УЛСЫН ХАМТАРСАН СУРГАЛТ, ДАДЛАГАД ЦЭРГИЙН БАГ ОРОЛЦУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

| № | Ажиллагааны нэр | Нэгдсэн (мян.төг) | Нөөцөөс хангах хувилбар (мян.төг) | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ЗХ-ний нөөцөөс | Урсгал хангалтаас | Худалдаж авах | Нөхөн төлбөрөөс |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. Энхийг дэмжих ажиллагаа | | | | | | |
| 1 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан VI ээлжийн цэргийн баг | 1,148,353.13 | 142,875.55 | 15,378.00 | 211,959.57 | 778,140.00 |
| 2 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан VII ээлжийн цэргийн баг | 1,147,515.43 | 142,799.35 | 15,378.00 | 211,198.07 | 778,140.00 |
| 3 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд XIV ээлжийн артиллерийн сургалтын хөдөлгөөнт баг | 235,959.18 | 31,042.62 | 14,286.20 | 40,645.36 | 149,985.00 |
| 4 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд XV ээлжийн артиллерийн сургалтын хөдөлгөөнт баг | 235,959.18 | 31,042.62 | 14,286.20 | 40,645.36 | 149,985.00 |
| 5 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан VI ээлжийн цэргийн баг | 1,288,722.80 | 35.59 | 17,177.80 | 313,684.41 | 957,825.00 |
| 6 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан VII ээлжийн цэргийн баг | 1,288,722.80 | 35.59 | 17,177.80 | 313,684.41 | 957,825.00 |
| 7 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нисдэг тэрэгний засвар үйлчилгээний IV ээлжийн цэргийн баг | 71,019.75 | 9,486.80 | 9,183.70 | 14,234.25 | 38,115.00 |
| 8 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нисдэг тэрэгний засвар үйлчилгээний V ээлжийн цэргийн баг | 71,019.75 | 9,486.80 | 9,183.70 | 14,234.25 | 38,115.00 |
| 9 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд Бельги Улсын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэх нисэх онгоцны буудлын хамгаалалтын салааны III ээлжийн цэргийн баг | 554,047.82 | 93,148.29 | 15,125.50 | 94,819.03 | 350,955.00 |
| 10 | Афганистан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд Бельги Улсын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэх нисэх онгоцны буудлын хамгаалалтын салааны IV ээлжийн цэргийн баг | 554,047.82 | 93,148.29 | 15,125.50 | 94,819.03 | 350,955.00 |
| 11 | Судан Улсын Дарфур муж дахь НҮБ, Африкийн холбооны хамтарсан энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн хээрийн II шатны эмнэлгийн III ээлжийн цэргийн баг | 767,633.94 | 65,486.29 | 15,212.80 | 240,939.85 | 445,995.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | Судан Улсын Дарфур муж дахь НҮБ, Африкийн холбооны хамтарсан энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн хээрийн II шатны эмнэлгийн IV ээлжийн цэргийн баг | 767,883.94 | 65,486.29 | 15,212.80 | 241,189.85 | 445,995.00 |
| 13 | Өмнөд Судан Улс дахь НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцох Мотобуудлагын батальоны II ээлжийн цэргийн баг | 7,099,801.34 | 566,314.31 | 20,121.30 | 1,211,915.73 | 5,301,450.00 |
| | Энхийг дэмжих ажиллагааны дүн | 15,230,686.87 | 1,250,388.39 | 192,849.30 | 3,043,969.17 | 10,743,480.00 |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | 2. Хамтарсан сургалт, дадлага | | | | | |
| 14 | Катар Улстай хамтарсан "Шийдэмгий шийдвэр" сургалт, дадлага | 118,538.11 | 10,064.42 | | 108,473.69 | |
| 15 | БНХАУ-тай хамтарсан "Энхийн элч" сургалт, дадлага | 23,115.07 | 586.00 | | 22,529.07 | |
| 16 | Турк Улстай хамтарсан "Нүүдэлчин дайчин" тусгай хүчний сургалт, дадлага | 84,255.52 | 41,604.55 | | 42,650.97 | |
| 17 | “Khaan quest” энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургалт, дадлага | 594,408.87 | 10,314.20 | | 584,094.67 | |
| 18 | “Олон улсын хүчний тогтсон ажиллагааны журам” олон улсын төлөвлөлтийн багийн команд штабын сургууль | 11,932.62 | | | 11,932.62 | |
| 19 | АНУ-ын “Дэлхийн энхийн ажиллагааны сан”-тай хамтарсан сургалтууд | 135,783.26 | 234.40 | 12,764.20 | 122,784.66 | |
| 20 | Бангладеш Улсад зохион байгуулагдах "Shanti doot-3" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургалт, дадлага | 10,238.67 | 297.00 | 6,600.00 | 3,341.67 | |
| 21 | БНЭУ-д зохион байгуулагдах "Нүүдэлчин заан" сургалт, дадлага | 76,091.26 | 205.00 | 8,300.00 | 67,586.26 | |
| 22 | ОХУ-д зохион байгуулагдах "Сэлэнгэ-2" хээрийн сургалт, дадлага | 408,556.23 | 61,016.86 | 23,686.30 | 323,853.07 | |
| 23 | Турк Улсад зохион байгуулагдах "Анадолу" тусгай хүчний олон улсын сургалт, дадлага | 85,196.46 | 1,752.46 | | 83,444.00 | |
| | Сургалт, дадлагын дүн | 1,548,116.09 | 126,074.89 | 51,350.50 | 1,370,690.69 | 0.00 |
| | Бүгд дүн | 16,778,802.95 | 1,376,463.29 | 244,199.80 | 4,414,659.87 | 10,743,480.00 |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 71 | Улаанбаатар хот

**Жагсаалт батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.7, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15.10-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүн амын аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан шууд гэрээ байгуулан худалдан авах эм, дархлаажуулах бэлдмэл, цус, цусан бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх жагсаалтад орсон эм, дархлаажуулах бэлдмэл, цус, цусан бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эмийн үйлдвэр, ханган нийлүүлэгчтэй шууд гэрээ байгуулан импортоор шууд нийлүүлэх эрх олгохыг Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Д.Хаянхярваад үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** **Н.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2012 оны 71 дүгээр тогтоолын хавсралт

## ШУУД ГЭРЭЭ БАЙГУУЛАН ХУДАЛДАН АВАХ ЭМ, ДАРХЛААЖУУЛАХ БЭЛДМЭЛ, ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮН, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

### Нэг. Эм, дархлаажуулах бэлдмэл

Эм, дархлаажуулах бэлдмэлийн олон улсын нэр

1. Микрогинон 21+7 цикл
2. Окситоцин
3. Депопровера
4. Гидралазин гидрохлорид

5. Метилэргометрин
6. Ригевидон
7. Постинор
8. Төмрийн сульфат
9. Төмрийн декстран
10. Такролимус капсул
11.Сүрьеэгийн эсрэг сэргийлэх тарилга (БЦЖ)
12. Полимиелитийн (Хүүхдийн тархи нугасны халдварт саа) эсрэг сэргийлэх тарилга
13. В гепатитын эсрэг сэргийлэх тарилга
14. Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилга
15. Таван (сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит, хемофилюс, инфлюенза В) дархлаажуулах бэлдмэл
16. Сахуу татран өвчний эсрэг сэргийлэх тарилга
17. Менингококкийн эсрэг сэргийлэх тарилга
18. Пневмококкийн эсрэг сэргийлэх тарилга
19. Томуугийн эсрэг сэргийлэх тарилга

## Хоёр. Цус, цусан бүтээгдэхүүн

Цус, цусан бүтээгдэхүүний нэр

1. Бүхэл цус
2. Даршилсан улаан эс
3. Улаан эсийн өтгөрүүлэгч
4. Угаасан улаан эс
